

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/18/НА-СТА-ЗГТС

|   |  |
|---|--|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a><br><br>Аудитын менежер: Г.Гүнжидмаа<br>Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a><br><br>Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ<br>Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:bolor-erdened@audit.gov.mn">bolor-erdened@audit.gov.mn</a><br><br>Аудитор: Ц.Мөнхтуяа<br>Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:munkhtuyats@audit.gov.mn">munkhtuyats@audit.gov.mn</a> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
САНГИЙН ДАРГА Я.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 01/660

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн үлдэгдлээс 2.3 хувь буюу 5,220.0 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 3.7 хувь буюу 8,302.1 сая төгрөгийн зээл эргэлзээтэй, 41.8 хувь буюу 108,743.5 сая төгрөгийн зээл "муу зээл" -ийн ангилалд бүртгэгдсэн, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 7,823.8 сая төгрөгөөр тасалсан, зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 701.1 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээг хийж, эргэлтэд оруулаагүй зэрэг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын 15.1-д заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/168 дугаар тушаалаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 20,500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлийг баталж, төслийн сонгон шалгаруулалтад 608 аж ахуйн нэгж, байгууллага 87,826.9 сая төгрөгийн хүсэлт ирүүлж оролцсоноос барьцаа хөрөнгийн шаардлага хангасан 156 төсөл шалгарч, 19,181.8 сая төгрөгөөр санхүүжүүлж, 815 ажлын

Z:\Yawsan\_Bichig\2023\0315 SNAG-118.Docx

0001051285

байрыг хадгалж, 1002 ажлын байрыг шинээр бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоолоор сангийн ажлын албыг татан буулгаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-ыг байгуулж, агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр холбогдох хуульд заасныг зөрчин, жил бүр сангийн хөрөнгөөс эх үүсвэрийг бүрдүүлэн, зарцуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 6 хөтөлбөр, 4 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 36 арга хэмжээг бүрэн, 8 арга хэмжээг 90.0 хувь, 8 арга хэмжээг 70.0 хувь, 2 арга хэмжээг 30.0 хувь буюу нийт дүнгээр 91.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код          | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл            | Эцсийн үлдэгдэл           |
|--------------|--|---------------------------|---------------------------|
| <b>1</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>                   | <b>255,573,795,783.22</b> | <b>258,254,585,498.81</b> |
| <b>31</b>    | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                                | <b>0.01</b>               | <b>-</b>                  |
| <b>31200</b> | <b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>                     | <b>0.01</b>               | <b>-</b>                  |
| 31110        | Төгрөг   | 0.01                      | -                         |
| <b>33</b>    | <b>АВЛАГА</b>  | <b>254,978,361,783.21</b> | <b>257,166,355,548.81</b> |
| 33300        | Татаас, санхүүжилтийн авлага                         | -                         | 6,553,043,611.06          |
| <b>33500</b> | <b>Бусад авлага</b>                                  | <b>130,128,301.21</b>     | <b>275,561,632.21</b>     |
| 33510        | Байгууллагаас авах авлага                            | 126,858,714.21            | 144,479,845.21            |
| 33520        | Хувь хүмүүсээс авах авлага                           | 3,269,587.00              | 131,081,787.00            |
| <b>33600</b> | <b>Зээлийн авлага</b>                                | <b>254,848,233,482.00</b> | <b>250,337,750,305.54</b> |
| 33610        | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага           | 254,848,233,482.00        | 250,337,750,305.54        |
| 33615        | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл         | 254,848,233,482.00        | 250,337,750,305.54        |
| <b>35</b>    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                | <b>595,434,000.00</b>     | <b>1,088,229,950.00</b>   |
| 35300        | Бэлэн бүтээгдэхүүн                                   | 595,434,000.00            | 387,172,000.00            |
| 35400        | Хангамжийн материал                                  | -                         | 701,057,950.00            |
| 35470        | Бусад хангамжийн материал                            | -                         | 701,057,950.00            |
| <b>3</b>     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>                 | <b>255,573,795,783.22</b> | <b>258,254,585,498.81</b> |
| <b>4</b>     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>                           | <b>16,981,044,439.45</b>  | <b>7,177,169,367.61</b>   |
| <b>41</b>    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                     | <b>970,887,511.09</b>     | <b>731,919,867.61</b>     |
| <b>41300</b> | <b>Өглөг</b>   | <b>817,444,666.00</b>     | <b>568,694,666.00</b>     |
| 41310        | Ажилчидтай холбогдсон өглөг                          | 5,750,000.00              | -                         |
| <b>41360</b> | <b>Бусад өглөг</b>                                   | <b>811,694,666.00</b>     | <b>568,694,666.00</b>     |
| 41361        | Байгууллагад төлөх өглөг                             | 811,694,666.00            | 568,694,666.00            |
| <b>41400</b> | <b>Урьдчилж орсон орлого</b>                         | <b>153,442,845.09</b>     | <b>163,225,201.61</b>     |
| <b>42</b>    | <b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                        | <b>16,010,156,928.36</b>  | <b>6,445,249,500.00</b>   |
| 42200        | Урт хугацаат зээл                                    | 16,010,156,928.36         | 6,445,249,500.00          |
| 42210        | Төгрөг   | 16,010,156,928.36         | 6,445,249,500.00          |
| 42211        | Бонд   | 14,564,907,428.36         | -                         |
| 42217        | Санхүүгийн бусад байгууллага                         | 1,445,249,500.00          | 6,445,249,500.00          |
| <b>5</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>                  | <b>238,592,751,343.77</b> | <b>251,077,416,131.20</b> |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                   | <b>238,592,751,343.77</b> | <b>251,077,416,131.20</b> |
| 51200        | Хуримтлагдсан үр дүн                                 | 238,592,751,343.77        | 251,077,416,131.20        |
| 51210        | Өмнөх үеийн үр дүн                                   | 228,498,773,751.78        | 238,388,264,528.53        |
| 51220        | Тайлант үеийн үр дүн                                 | 10,093,977,591.99         | 12,689,151,602.67         |
| <b>6</b>     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b> | <b>255,573,795,783.22</b> | <b>258,254,585,498.81</b> |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код           | Үзүүлэлт  | Өмнөх он                 | Тайлант он               |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| <b>1</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                            | <b>11,505,403,501.12</b> | <b>14,313,340,114.90</b> |
| <b>12</b>     | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>11,505,403,501.12</b> | <b>14,313,340,114.90</b> |
| 1200          | Нийтлэг татварын бус орлого                                       | 11,505,403,501.12        | 14,313,340,114.90        |
| 120002        | Хүүгийн орлого  | 2,884,233,138.37         | 2,292,805,526.46         |
| 1200021       | Хүүгийн орлого  | 2,884,233,138.37         | 2,292,805,526.46         |
| 120003        | Торгуулийн орлого   | 7,642,360,358.68         | 11,193,184,492.77        |
| 1200031       | Нэмэгдүүлсэн хүүгийн орлого                                       | 118,222,834.27           | 127,195,381.29           |
| 1200032       | Алдангийн орлого  | 7,524,137,524.41         | 11,065,989,111.48        |
| <b>120004</b> | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                           | <b>294,017,004.07</b>    | <b>226,292,145.67</b>    |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлого                                     | 17,021,523.17            | 222,598,003.67           |
| 12000411      | ҮҮАО /Үндсэн зээлийн төлбөр/                                      | 13,332,023.17            | 222,598,003.67           |
| 12000415      | Үндсэн үйл ажиллагааны бусад орлого                               | 3,689,500.00             | -                        |
| 1200042       | Туслах үйл ажиллагааны орлого                                     | 276,995,480.85           | 3,694,142.00             |
| 12000422      | ТҮАО /Банкны хяналтын зардал/                                     | 18,859,698.67            | 2,856,723.80             |
| 12000425      | ТҮАО /Бусад/  | 174,135,782.18           | 837,418.20               |
| 12000428      | Оёдлын нэгдсэн холбоо   | 84,000,000.00            | -                        |
| 1200043       | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                                     | 0.05                     | -                        |
| 120018        | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -<br>Материал                   | 684,793,000.00           | 601,057,950.00           |
| <b>2</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>                           | <b>1,395,725,909.13</b>  | <b>1,624,188,512.23</b>  |
| <b>21</b>     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>1,395,725,909.13</b>  | <b>1,624,188,512.23</b>  |
| 210           | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 1,395,725,909.13         | 1,552,329,700.00         |
| 2101          | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил                                | 27,892,024.11            | -                        |
| 210101        | Үндсэн цалин  | 27,892,024.11            | -                        |
| 2108          | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний<br>төлбөр, хураамж       | 12,300,000.00            | -                        |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил<br>үйлчилгээний төлбөр хураамж | 12,300,000.00            | -                        |
| 2109          | Бараа үйлчилгээний бусад зардал                                   | 1,355,533,885.02         | 1,552,329,700.00         |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                                   | 1,355,533,885.02         | 1,552,329,700.00         |
| 211           | ХҮҮ   | -                        | 71,858,812.23            |
| 2112          | Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр                              | -                        | 71,858,812.23            |
| 211201        | Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр                              | -                        | 71,858,812.23            |
| <b>3</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>                          | <b>10,109,677,591.99</b> | <b>12,689,151,602.67</b> |
| <b>5</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН<br/>(V)</b>                    | <b>15,700,000.00</b>     | <b>-</b>                 |
| 225           | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ  | 15,700,000.00            | -                        |
| 225011        | Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа<br>материал            | 15,700,000.00            | -                        |
| <b>6</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН<br/>(VI=III+IV-V)</b>              | <b>10,093,977,591.99</b> | <b>12,689,151,602.67</b> |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Хуримтлагдсан үр дүн      | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------|--|
| <b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>228,498,773,751.78</b> | <b>228,498,773,751.78</b>              |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                   | 228,498,773,751.78        | 228,498,773,751.78                     |
| Тайлант үеийн үр дүн                         | 10,093,977,591.99         | 10,093,977,591.99                      |
| <b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>238,592,751,343.77</b> | <b>238,592,751,343.77</b>              |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   | (204,486,815.24)          | (204,486,815.24)                       |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                   | 238,388,264,528.53        | 238,388,264,528.53                     |
| <b>Тайлант үеийн үр дүн</b>                  | <b>12,689,151,602.67</b>  | <b>12,689,151,602.67</b>               |
| <b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>251,077,416,131.20</b> | <b>251,077,416,131.20</b>              |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код       | Үзүүлэлт   | Өмнөх он                 | Тайлант он               |
|-----------|--|--------------------------|--------------------------|
| <b>1</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                | <b>32,183,161,440.67</b> | <b>42,166,953,551.64</b> |
| <b>12</b> | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>32,142,969,416.56</b> | <b>42,166,953,551.64</b> |
| 1200      | Нийтлэг татварын бус орлого  | 32,142,969,416.56        | 42,166,953,551.64        |
| 120002    | Хүүгийн орлого   | 2,731,633,432.95         | 2,087,271,048.33         |
| 1200021   | Хүүгийн орлого   | 2,731,633,432.95         | 2,087,271,048.33         |
| 120003    | Торгуулийн орлого  | 283,477,995.55           | 354,891,224.75           |
| 1200031   | Нэмэгдүүлсэн хүүгийн орлого  | 14,986,533.48            | 8,326,704.41             |
| 1200032   | Алдангийн орлого   | 268,491,462.07           | 346,564,520.34           |
| 120004    | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 29,127,857,988.06        | 39,724,791,278.56        |
| 1200041   | Үндсэн үйл ажиллагааны орлого  | 28,793,723,508.16        | 39,634,765,725.56        |
| 12000411  | ҮҮАО /Үндсэн зээлийн төлбөр/   | 28,743,872,041.15        | 34,634,765,725.56        |
| 12000413  | ҮҮАО /Мал хамгаалах сан/   | 22,845,000.00            | -                        |
| 12000414  | ҮҮАО /Өмнөговь/  | -                        | 5,000,000,000.00         |
| 12000415  | Үндсэн үйл ажиллагааны бусад орлого  | 27,006,467.01            | -                        |
| 1200042   | Туслах үйл ажиллагааны орлого  | 334,134,479.90           | 90,025,553.00            |
| 12000421  | Туслах үйл ажиллагааны орлого /Хөдөлгөөнт цахилгаан саалтуур/                | 13,728,000.00            | 1,330,000.00             |
| 12000422  | Туслах үйл ажиллагааны орлого /Банкны хяналтын зардал/                       | 18,859,698.67            | 2,856,723.80             |
| 12000424  | Туслах үйл ажиллагааны орлого /АБТТ/   | 17,427,000.05            | 78,170,400.00            |
| 12000425  | Туслах үйл ажиллагааны орлого /Бусад/  | 174,324,781.18           | 4,180,429.20             |
| 12000426  | Туслах үйл ажиллагааны орлого /ЦЦТТ/   | 25,795,000.00            | 3,488,000.00             |
| 12000428  | Оёдлын нэгдсэн холбоо  | 84,000,000.00            | -                        |
| <b>13</b> | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>40,192,024.11</b>     | <b>-</b>                 |
| 1311      | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 40,192,024.11            | -                        |
| 131105    | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 40,192,024.11            | -                        |
| <b>2</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>                                | <b>2,973,161,440.67</b>  | <b>8,105,373,311.06</b>  |
| <b>21</b> | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>2,973,161,440.67</b>  | <b>8,105,373,311.06</b>  |
| 210       | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ   | 2,291,402,604.53         | 1,552,329,700.00         |
| 2101      | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил   | 27,892,024.11            | -                        |
| 210101    | Үндсэн цалин   | 27,892,024.11            | -                        |
| 2108      | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                     | 12,300,000.00            | -                        |
| 210801    | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж               | 12,300,000.00            | -                        |
| 2109      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 2,251,210,580.42         | 1,552,329,700.00         |
| 210901    | Бараа үйлчилгээний бусад зардал  | 2,251,210,580.42         | 1,552,329,700.00         |
| 213       | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 681,758,836.14           | 6,553,043,611.06         |
| 2133      | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг                                  | 681,758,836.14           | 6,553,043,611.06         |
| 213303    | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                        | 6,553,043,611.06         |
| 213306    | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг                                  | 681,758,836.14           | -                        |
| <b>3</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>                       | <b>29,210,000,000.00</b> | <b>34,061,580,240.58</b> |
| <b>4</b>  | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>                            | <b>-</b>                 | <b>-</b>                 |
| <b>5</b>  | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>                             | <b>-</b>                 | <b>-</b>                 |

|        |   |                            |                            |
|--------|---|----------------------------|----------------------------|
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>                  | -                          | -                          |
| 9      | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>                             | -                          | -                          |
| 10     | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                             | <b>29,210,000,000.00</b>   | <b>34,061,580,240.59</b>   |
| 23     | <b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>                         | <b>810,000,000.00</b>      | <b>19,496,672,812.23</b>   |
| 230    | Дотоодын зах зээлээс санхүүжих эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 810,000,000.00             | 19,496,672,812.23          |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл   | 810,000,000.00             | 19,496,672,812.23          |
| 24     | <b>Гадаад зээлийн үндсэн төлбөр</b>                                       | <b>28,400,000,000.00</b>   | <b>14,564,907,428.36</b>   |
| 241001 | Засгийн газрын бондын үндсэн төлбөр                                       | 28,400,000,000.00          | 14,564,907,428.36          |
| 7      | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>              | <b>(29,210,000,000.00)</b> | <b>(34,061,580,240.59)</b> |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>                        | 0.00                       | <b>(0.01)</b>              |
| 14     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                          | 0.01                       | 0.01                       |
| 15     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                         | 0.01                       | -                          |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт   | Төлөвлөгөө                 | Гүйцэтгэл                  | Зөрүү                     | Хувь        |
|--------|--|----------------------------|----------------------------|---------------------------|-------------|
| II     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>32,000,000,000.00</b>   | <b>4,931,765,383.87</b>    | <b>27,068,234,616.13</b>  | <b>15.4</b> |
| 23     | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | <b>32,000,000,000.00</b>   | <b>4,931,765,383.87</b>    | <b>27,068,234,616.13</b>  | <b>15.4</b> |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл                                      | 32,000,000,000.00          | 4,931,765,383.87           | 27,068,234,616.13         | 15.4        |
| III    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>32,000,000,000.00</b>   | <b>11,484,808,994.92</b>   | <b>20,515,191,005.08</b>  | <b>35.9</b> |
| 35     | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | <b>50,000,000,000.00</b>   | <b>26,049,716,423.28</b>   | 23,950,283,576.72         | 52.1        |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 50,000,000,000.00          | 26,049,716,423.28          | 23,950,283,576.72         | 52.1        |
| 37     | <b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>                                   | <b>(18,000,000,000.00)</b> | <b>(14,564,907,428.36)</b> | <b>(3,435,092,571.64)</b> | <b>80.9</b> |
| 370001 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | (18,000,000,000.00)        | (14,564,907,428.36)        | (3,435,092,571.64)        | 80.9        |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 0.00                       | 0.01                       | -                         | -           |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 0.00                       | 0.00                       | -                         | -           |

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 109,652.8 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 108,743.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 909.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Аудитын явцад төсвийн гүйцэтгэлийн тайланд 181.0 сая, мөнгөн гүйлгээний тайланд 13.9 сая төгрөгийн, нийт 194.9 сая төгрөгийн бүртгэл тайлагналын<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны утга  | Нийт алдаа |            | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |            | Үүнээс:    |            |              |    |
|---|------------|------------|-----------------------------------|-----|--------------------------|------------|------------|------------|--------------|----|
|   | Тоо        | Дүн        | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн        | Залруулсан |            | Залруулаагүй |    |
| 2   | 3          | 4          | 5                                 | 6   | 7                        | 8          | 9          | 10         | 11           | 12 |
| Зээлийн илүү төлөлт 108 харилцагчийн 13,875.7 мянган төгрөгийн илүү төлөлтийг УОО дансанд бүртгэлгүй хасах үлдэгдэлтэй авлагын тайлан гаргасан байна. | 1          | 13,857.70  |                                   |     | 1                        | 13,857.70  | 1          | 13,857.70  |              |    |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэр данс зөрүүгийн 181,000.0 мянган төгрөгийг тохируулаагүй байна.   | 1          | 181,000.00 |                                   |     | 1                        | 181,000.00 | 1          | 181,000.00 |              |    |
|   | 2          | 194,857.70 | -                                 | -   | 2                        | 194,857.70 | 2          | 194,857.70 | -            | -  |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдаа, зөрчлийн товч утга  | Нийт алдаа, зөрчлийн дүн |            | Үүнээс:       |     |                 |     |         |     |   |     |  |
|--|--------------------------|------------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|---|-----|--|
|  | Тоо                      | Дүн        | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн |     |  |
|  |                          |            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                     | Дүн |  |
| 2  | 3                        | 4          | 5             | 6   | 7               | 8   | 9       | 10  | 11                                      | 12  |  |
| Тайлант хугацаанд зарцуулсан 208,262.0 мянган төгрөгийн бараа материалын тайланд бүртгэлтэй борлуулах зорилготой тоног төхөөрөмжийн зарцуулалтад бараа материалын тайлан бэлтгэж, тайлагнаагүй байна.  | 1                        | 208,262.00 |               |     |                 |     |         | 1   | 208,262.00                              |     |  |
| Төсөвт байгууллагын өөрийн орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс 7,823,776.4 мянган төгрөгөөр тасалсан байна.  | 1                        | -          |               |     |                 |     |         | 1   | -                                       |     |  |
| Зээлийн эргэн төлөлтөд хураан авсан борлуулах зорилготой 311,183.0 мянган төгрөгийн 12,671.2 м2 талбай бүхий газар, 292,875.0 мянган төгрөгийн 275 м2 бүхий 5 айлын орон сууц, 97,000.0 мянган төгрөгийн 5,864.6 м2 бүхий 2 үйлчилгээний зориулалттай нийт 701,058.0 | 1                        | 701,058.00 |               |     |                 |     |         | 1   | 701,058.00                              |     |  |

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

|  |          |                       |   |   |          |                       |          |                   |   |   |
|--|----------|-----------------------|---|---|----------|-----------------------|----------|-------------------|---|---|
| мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг одоог хүртэл зах зээлийн үнэлгээ хийж, эргэлтэд оруулаагүй байна.   |          |                       |   |   |          |                       |          |                   |   |   |
| ЖДҮХС-ийн төсвөөс агентлагийн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлж байгаа нь сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.   | 1        | -                     |   |   |          |                       | 1        | -                 |   |   |
| Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нийт зээлийн авлагын 41.8 хувь буюу 108,743,500.0 мянган төгрөг нь "муу зээл" -ийн ангилалд бүртгэлтэй, 8,302.1 сая төгрөгийн зээл эргэлзээтэй ангилалд шилжиж, муу зээлийн ангиллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй, өмнөх оноос 5.7 хувиар өссөн байна. | 1        | 108,743,500.00        |   |   | 1        | 108,743,500.00        |          |                   |   |   |
| Өмнөх аудитаар өгөгдсөн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээгээр олгосон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг fiscus программд оруулж, нэмэлт хөгжүүлэлт хийх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.                                  | 1        | -                     |   |   | 1        | -                     |          |                   |   |   |
|  | <b>6</b> | <b>109,652,820.00</b> | - | - | <b>2</b> | <b>108,743,500.00</b> | <b>4</b> | <b>909,320.00</b> | - | - |